

**Golomt Capital<sup>®</sup>**

# ДЭЛХИЙН

---

**ЗАХ ЗЭЭЛИЙН ДОЛОО  
ХОНОГИЙН ТОЙМ**

**2025.04.28**

## Хөрөнгийн зах зээлийн онцлох мэдээ


### ТОВЧ

- АНУ-ын хөрөнгийн зах зээл өнгөрсөн долоо хоногт өсөлттэй байлаа.
- АНУ-ын засгийн газрын бондын зах зээл өнгөрсөн долоо хоногт бага зэрэг өсөлттэй байлаа.
- АНУ-ын бизнесийн идэвхжил сүүлийн 16 сарын хамгийн бага түвшинд удааширсан нь тогтоогдсон байна.
- Улс төрийн товчоо (Politburo) гадаад орчноос ирж болзошгүй шокуудад бэлэн байхын тулд "яаралтай арга хэмжээний төлөвлөгөө" боловсруулна гэдгээ мэдэгдэв.
- Huawei Technologies компани хамгийн дэвшилтэт хиймэл оюун ухааны (AI) процессороороо түршилт хийхэд бэлдэж байна.
- Тус шинэ чипийг Ascend 910D хэмээн нэрлэж байгаа бөгөөд анхны түршилтын загварууд 5-р сарын сүүлээр бэлэн болох төлөвтэй байна.



### S&P 500 индексийн 2025 оны таамаглал

|                     |              |
|---------------------|--------------|
| Deutsche Bank       | 7,000        |
| Société Générale    | 6,750        |
| BMO Capital Markets | 6,700        |
| Bank of America     | 6,666        |
| Barclays            | 6,600        |
| RBC Capital Markets | 6,600        |
| Wells Fargo         | 6,500        |
| Citigroup           | 6,500        |
| Goldman Sachs       | 6,500        |
| Morgan Stanley      | 6,500        |
| JPMorgan Chase      | 6,500        |
| UBS                 | 6,400        |
| <b>Дундаж</b>       | <b>6,678</b> |







## АНУ-ын зах зээлийн онцлох мэдээ 2025.04.21-04.27

### АНУ-ЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ ӨСЛӨӨ

АНУ-ын хөрөнгийн зах зээл өнгөрсөн долоо хоногт өсөлттэй байлаа. Үүнд АНУ, БНХАУ-ын хооронд үргэлжилж буй худалдааны хурцадмал байдал намжих төлөвтэй гэсэн хэд хэдэн мэдээлэл эерэг нөлөө үзүүлэв. Мөн АНУ бусад худалдааны түнш орнуудтай ойрын хугацаанд хэлэлцээрт хүрч магадгүй гэсэн таамаг зах зээлд нэмэлт дэмжлэг болсон бөгөөд Ерөнхийлөгч Дональд Трамп Холбооны Нөөцийн Сангийн дарга Жером Пауэллийг огцруулах тухай асуудлыг дахин бодох талаар мэдэгдэл хийсэн нь мөн зах зээлийг тайвшруулсан байна.

Индексүүдийн хувьд, Nasdaq Composite индекс өмнөх долоо хоногийн үналтаас огцом сэргэн тэргүүлсэн бол жижиг болон дунд зах зээлийн үнэлгээтэй хувьцаанууд гурав дахь долоо хоног дараалан өсөлт үзүүлжээ. Мөн зарим компанийн ашиг орлогын тайлангууд хүлээлтээс давсан нь зах зээлийн эерэг сэтгэл зүйд нэмэлт түлхэц болсон бололтой.

FactSet-ийн мэдээлснээр, баасан гарагийн байдлаар эхний улирлын үр дүнгээ танилцуулсан компаниудын 73% нь шинжээчдийн орлогын таамгаас давсан үзүүлэлттэй байв. Харин T. Rowe Price-ийн арилжаачдын ажигласнаар, долоо хоногийн түрш зах зээлийн идэвхжил болон арилжааны хэмжээ жилийн дундаж түвшнээс доогуур хэвээр байсан байна.

### ЗАСГИЙН ГАЗРЫН БОНДЫН ҮНЭ ӨСЛӨӨ

АНУ-ын засгийн газрын бондын зах зээл өнгөрсөн долоо хоногт бага зэрэг өсөлттэй байлаа. Ихэнх хугацаат бондын, ялангуяа урт хугацаат бондын өгөөж буурсан нь эдийн засгийн удаашралын хүлээлт нэмэгдсэнтэй холбоотой байв. (Бондын үнэ ба өгөөж нь эсрэг чиглэлд хөдөлдөг.)

Орон нутгийн засгийн газрын (municipal) бондууд харьцангуй сүл гүйцэтгэлтэй байсан бөгөөд улирлын шинжтэй сулрал энэ хөрөнгийн ангилалд үргэлжлэн дарамт үзүүлсэн байна. Гэсэн хэдий ч манай арилжаачдын тэмдэглэснээр, 5-р сарын 1-ний бондын мөнгөн урсгалыг дахин санхүүжүүлэх үйл явц нь бондын салбарт тодорхой хэмжээгээр дэмжлэг үзүүлэх төлөвтэй байна.

Үүний зэрэгцээ, хөрөнгө оруулалтын зэрэглэлтэй (investment-grade) компанийн бондууд АНУ-ын Засгийн газрын бондуудаас (Treasuries) давуу гүйцэтгэл үзүүлсэн бөгөөд шинэ гаргасан бондын хэмжээ зах зээлийн хүлээлттэй нийцсэн бөгөөд ихэнх шинэж бондууд хэт захиалгатай (oversubscribed) байлаа. Энэ нь хөрөнгө оруулагчид чанартай, найдвартай үнэт цаас эрэлхийлж байгааг харуулж байна.

**Эдийн засгийн талаарх мэдээллийн хүрээнд,** S&P Global байгууллагаас 4-р сарын Худалдан авагчдын менежерүүдийн индекс (PMI)-ийн судалгааны үр дүнг танилцууллаа. Энэхүү мэдээллээр АНУ-ын бизнесийн идэвхжил сүүлийн 16 сарын хамгийн бага түвшинд удааширсан нь тогтоогдсон байна.

Үйлдвэрлэлийн салбарын идэвхжил хүлээлтээс давж, 3-р сард 50.2 байсан түвшнээс 4-р сард 50.7 болж өссөн ч, үйлчилгээний салбарын өсөлт огцом саарсан нь нийт индексийг өмнөх сарын 53.5-аас 51.2 болгон бууруулахад голлон нөлөөлжээ. (50-иас дээш үзүүлэлт эдийн засгийн тэлэлтийг, 50-аас доош үзүүлэлт агшилтыг илтгэдэг.)



## Хөрөнгийн зах зээлийн онцлох мэдээ 2025.04.21-04.27

### БНХАУ-ЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ ӨСЛӨӨ

БНХАУ-ын хөрөнгийн зах зээл өнгөрсөн долоо хоногт өсөлттэй байлаа. АНУ-ын тарифын нөлөөллөөс эдийн засгаа хамгаалахын тулд Бээжин нэмэлт эдийн засгийн дэмжлэгийн арга хэмжээнүүд авч хэрэгжүүлэх төлөвтэй гэсэн хүлээлт өссөн нь зах зээлд эерэг нөлөөлөв. FactSet-ийн мэдээлснээр, дотоодын голлох CSI 300 индекс 0.46%, Шанхайн нийлмэл индекс 0.61%-иар нэмэгдсэн бол Хонконгийн Hang Seng индекс 2.82%-ийн өсөлт үзүүлсэн байна.

Баасан гарагт, Коммунист Намын 24 гишүүнтэй бодлого тодорхойлогч байгууллага болох Улс төрийн товчоо (Politburo) гадаад орчноос ирж болзошгүй шокуудад бэлэн байхын тулд "яаралтай арга хэмжээний төлөвлөгөө" боловсруулна гэдгээ мэдэгдэв. Bloomberg агентлагийн мэдээлснээр, мөн тус бүлэг технологи, хэрэглээ, худалдааг дэмжих шинэ мөнгөний бодлогын хэрэгслүүд болон санхүүжилтийн хөтөлбөрүүдийг бий болгохоор төлөвлөж байгааг онцолсон байна. Түүнчлэн "эдийн засгийн хөгжлийн үндэс суурь, нийгмийн тогтвортой байдлыг бүх талаар бэхжүүлэх" амлалтыг өгчээ.

Хятад улсын төрийн тэргүүн Ши Жиньпиний удирдсан энэ зөвлөлөөс гаргасан мэдэгдэл нь Бээжин АНУ-тай өрнөж буй худалдааны дайны нөхцөлд эдийн засгаа дэмжихэд илүү тэвчээртэй, шат дараалсан арга барил баримталж буйг харуулж байна. Олон шинжээчийн үзэж байгаагаар, АНУ-ын тарифын өсөлт нь ойрын хугацаанд Хятадын эдийн засагт илүү хүчтэй нөлөөлж эхлэх төлөвтэй байна. Сануулахад, Трампын засаг захиргаа 4-р сарын эхээр БНХАУ-аас импортлох бараа бүтээгдэхүүнд нийт 145%-ийн тариф тогтоосон.

Гэсэн ч, Хятадын 1-р улирлын эдийн засгийн өсөлт хүлээлтээс давсан үзүүлэлттэй гарсан бөгөөд Бээжингээс 3-р сард зарласан эдийн засгийн дэмжлэгийн багц хөтөлбөрүүд нь тус улсад нэмэлт арга хэмжээ авахаас өмнө тодорхой хугацааны боломж олгож байна.

Түүнчлэн, сүүлийн жилүүдэд Хятад улс мөнгөний хэтэрхий тэлэлтээс зайлсхийж, зээлжих орчныг хэтэрхий их сэдрээхээс болгоомжилж ирсэн ч Т. Rowe Price-ийн төрийн бондын шинжээч Крис Кушлисийн үзэж буйгаар, 2025 онд тарифын эдийн засгийн үр дагаврыг үнэлж үзсэний үндсэн дээр Бээжин шат дараатайгаар төсвийн нэмэлт дэмжлэг үзүүлэх бололцоотой. Кушлис мөн хэлэхдээ, АНУ-тай үүссэн худалдааны дайн богино хугацаанд Хятадын экспорт болон бизнесийн итгэлд цохилт өгөх ч, төв засгийн газар эдийн засгийн нөлөөллийг сааруулах санхүүгийн боломжтой хэвээр байна гэж дүгнэжээ.

Huawei Technologies компани хамгийн дэвшилтэт хиймэл оюун ухааны (AI) процессороороо туршилт хийхэд бэлдэж байгаа талаар Wall Street Journal (WSJ) Ням гарагт эх сурвалжийн мэдээлэлд үндэслэн мэдээллээ. Энэхүү алхам нь Хятадын технологийн аварга компанийг Nvidia (NASDAQ: NVDA)-ийн өндөр хүчин чадалтай зарим бүтээгдэхүүнийг орлох боломжийг олгох төлөвтэй байна.

Тус шинэ чипийг Ascend 910D хэмээн нэрлэж байгаа бөгөөд анхны туршилтын загварууд 5-р сарын сүүлээр бэлэн болох төлөвтэй гэж WSJ мэдээлэв. Huawei уг чипийг дотоодын томоохон технологийн компаниудад туршиж үзүүлэхээр санал болгосон бөгөөд Nvidia-ийн хиймэл оюун хөгжүүлэхэд өргөн хэрэглэгддэг H100 чипийн орон нутгийн орлогчийг бий болгох зорилготой байна гэж мэдээлсэн байна. АНУ-ын худалдааны хориг арга хэмжээ бараг зургаан жилийн турш үйлчилж буй хэдий ч, Huawei компани хагас дамжуулагчийн технологийн чадавхаа мэдэгдэхүйц ахиулсан. Үүний тод жишээ нь 2023 онд танилцуулсан Mate 60 ухаалаг утас юм.





**Хүснэгт 1: Өнгөрсөн долоо хоногт тайлангаа зарласан компаниуд**

| <b>E EARNINGS WHISPERS</b><br><b>Most Anticipated Earnings Releases</b><br>for the week beginning<br><b>April 21, 2025</b> |  |                                  |                                     |  |   |   |                                      |   |             |
|--|--|----------------------------------|-------------------------------------|--|---|---|--------------------------------------|---|-------------|
| Monday   |  | Tuesday                          |                                     | Wednesday                                |   | Thursday  |                                      | Friday                                  |             |
| Before Open  | After Close                                | Before Open                      | After Close                         | Before Open                              | After Close                               | Before Open   | After Close                          | Before Open                             | Before Open |
| CCBG<br><b>Capital City Bank</b>   | AGNC<br><b>AGNC</b>                        | VZ<br><b>verizon</b>             | TSX<br><b>TESLA</b>                 | BA<br><b>BOEING</b>                      | ORLY<br><b>O'Reilly AUTO PARTS</b>        | AAL<br><b>American Airlines</b>                           | INTC<br><b>intel</b>                 | SLB<br><b>slb</b>                       |             |
| DX<br><b>DYNEX CAPITAL INC.</b>  | WRB<br><b>Berkley</b>                      | GE<br><b>GE Aerospace</b>        | ENPH<br><b>ENPHASE</b>              | T<br><b>AT&amp;T</b>                     | ALK<br><b>Alaska AIRLINES</b>             | NOK<br><b>NOKIA</b>                                       | GOOGL<br><b>Alphabet</b>             | ABBV<br><b>abbvie</b>                   |             |
| WASH<br><b>WASHINGTON TRUST BANK INC.</b>  | AZZ<br><b>AZZ</b>                          | LMT<br><b>LOCKHEED MARTIN</b>    | ISRG<br><b>INTUITIVE SURGICAL</b>   | VRT<br><b>VERTIV</b>                     | CMG<br><b>CHIPOTLE</b>                    | FCX<br><b>FreightlinerMcWorther Commercial &amp; Govt</b> | CLS<br><b>Celestica</b>              | PSX<br><b>Phillips 66</b>               |             |
| GNTY<br><b>Guaranty Bank &amp; Trust</b>   | MEDP<br><b>MEDPACE</b>                     | RTX<br><b>RTX</b>                | SAP<br><b>SAP</b>                   | APH<br><b>Amphenol</b>                   | NOW<br><b>servicenow</b>                  | LUV<br><b>Southwest</b>                                   | TMUS<br><b>T-Mobile</b>              | SAIA<br><b>SALA</b>                     |             |
| CMA<br><b>Comerica</b>   | MCB<br><b>Metropolitan Commercial Bank</b> | DHR<br><b>DANAHER</b>            | COF<br><b>Capital One</b>           | PM<br><b>PHILIP MORRIS INTERNATIONAL</b> | IBM<br><b>IBM</b>                         | MRK<br><b>MERCK</b>                                       | AEM<br><b>AGNICO EAGLE</b>           | CL<br><b>COUGATE-PALMOLIVE</b>          |             |
| HBT<br><b>HBT Financial</b>  | BOKF<br><b>BOK FINANCIAL</b>               | QDIA<br><b>Quest Diagnostics</b> | STLD<br><b>Steel Dynamics, Inc.</b> | NFE<br><b>NEXTERA ENERGY</b>             | NEM<br><b>Newmont</b>                     | PEP<br><b>PEPSICO</b>                                     | BOYD<br><b>BOYD</b>                  | POR<br><b>Portland General Electric</b> |             |
| BOH<br><b>Bank of Hawaii</b>   | FLXS<br><b>FLEXSTEEL</b>                   | ELV<br><b>Elevance Health</b>    | EWBC<br><b>East West Bank</b>       | CHKP<br><b>CHECK POINT</b>               | LRCX<br><b>Lam RESEARCH</b>               | DOW<br><b>Dow</b>   | SRX<br><b>SKECHERS</b>               | LYB<br><b>Lyondellbasell</b>            |             |
|  | WTRU<br><b>WINTRUST</b>                    | NOC<br><b>NORTHROP GRUMMAN</b>   | RRC<br><b>RANGE RESOURCES</b>       | GEV<br><b>GE VERNOVA</b>                 | CCS<br><b>CENTURY COMMUNITIES</b>         | UNP<br><b>Union Pacific</b>                               | DOC<br><b>PRINCIPAL BEAUTY TRUST</b> | AVTR<br><b>avantar</b>                  |             |
|  | CALX<br><b>Calix</b>                       | KMB<br><b>Kimberly-Clark</b>     | BKH<br><b>Baker Hughes</b>          | GD<br><b>GENERAL DYNAMICS</b>            | TAN<br><b>TEXAS INSTRUMENTS</b>           | TSCO<br><b>TRACTOR SUPPLY CO</b>                          | VALE<br><b>VALE</b>                  | CHTR<br><b>Charter COMMUNICATIONS</b>   |             |
|  | CATY<br><b>Cathay Bank</b>                 | HAL<br><b>HALLIBURTON</b>        | MANH<br><b>Manhattan Associates</b> | VIRT<br><b>VIRTU FINANCIAL</b>           | LVS<br><b>Sands LAS VEGAS SANDS CORP.</b> | VLD<br><b>Valero</b>                                      | WY<br><b>Weyerhaeuser</b>            | CNC<br><b>CENTENE Corporation</b>       |             |
| http://eps.sh/cal  |  |                                  |                                     |  |   | © 2025 Earnings Whispers                                  |                                      |   |             |

**Хүснэгт 2: Энэ долоо хоногт тайлангаа зарлах компаниуд**

| <b>E EARNINGS WHISPERS</b><br><b>Most Anticipated Earnings Releases</b><br>for the week beginning<br><b>April 28, 2025</b> |                                 |                                      |                                 |  |                                      |                                     |                            |   |             |
|--|---------------------------------|--------------------------------------|---------------------------------|--|--------------------------------------|-------------------------------------|----------------------------|---|-------------|
| Monday   |                                 | Tuesday                              |                                 | Wednesday                              |                                      | Thursday                            |                            | Friday  |             |
| Before Open  | After Close                     | Before Open                          | After Close                     | Before Open                            | After Close                          | Before Open                         | After Close                | Before Open                                     | Before Open |
| DPZ<br><b>Dominos Pizza</b>  | WM<br><b>WASTE MANAGEMENT</b>   | SOFI<br><b>SoFi</b>                  | V<br><b>VISA</b>                | HUM<br><b>Humana</b>                   | MSFT<br><b>Microsoft</b>             | LLY<br><b>Lilly</b>                 | AMZN<br><b>amazon</b>      | FUBO<br><b>fubo TV</b>                          |             |
| MGM<br><b>MGM RESORTS INTERNATIONAL</b>  | NXP<br><b>NXP</b>               | PYPL<br><b>PayPal</b>                | SBUX<br><b>Starbucks</b>        | CAT<br><b>CATERPILLAR</b>              | META<br><b>Meta</b>                  | RBLX<br><b>ROBLOX</b>               | AAPL<br><b>Apple</b>       | XOM<br><b>ExxonMobil</b>                        |             |
| OPRA<br><b>Opera</b>   | FFRI<br><b>FF</b>               | UPS<br><b>ups</b>                    | SNAP<br><b>Snap Inc.</b>        | VMC<br><b>Vulcan Materials Company</b> | HOOD<br><b>Robinhood</b>             | CVS<br><b>CVS Health</b>            | NOI<br><b>IOT</b>          | AES<br><b>aes</b>                               |             |
| FMX<br><b>FEMSA</b>  | NUE<br><b>NUCOR</b>             | JBLU<br><b>jetBlue</b>               | FSR<br><b>First Solar</b>       | WDC<br><b>Western Digital</b>          | QCOM<br><b>Qualcomm</b>              | MCD<br><b>McDonald's</b>            | ROTT<br><b>reddit</b>      | CVX<br><b>Chevron</b>                           |             |
| ROP<br><b>Roper TECHNOLOGIES</b>   | TER<br><b>TERADYNE</b>          | RCLE<br><b>Royal Caribbean Group</b> | PPG<br><b>PPG</b>               | IP<br><b>INTERNATIONAL PAPER</b>       | GRBK<br><b>GREEN BRICK PAPER</b>     | SIR<br><b>SiriusXM</b>              | ABNB<br><b>airbnb</b>      | APOL<br><b>APOLLO</b>                           |             |
| BankUnited<br><b>BankUnited</b>  | WELL<br><b>welltower</b>        | KO<br><b>Coca-Cola</b>               | BKNG<br><b>BOOKING HOLDINGS</b> | GNRC<br><b>GENERAC</b>                 | ALB<br><b>ALBEMARLE</b>              | MA<br><b>mastercard</b>             | BBAI<br><b>BIG BEAR AI</b> | BEP<br><b>Brookfield</b>                        |             |
| BMRC<br><b>Bank of Marin</b>   | ABCB<br><b>AMERIS BANK</b>      | PFE<br><b>Pfizer</b>                 | GRVQ<br><b>QORVO</b>            | SMG<br><b>Scotts Miracle-Gro</b>       | NLY<br><b>ANNALY</b>                 | BAX<br><b>Baxter</b>                | TEAM<br><b>ATLASSIAN</b>   | CI<br><b>Cigna</b>                              |             |
| RVTY<br><b>revvity</b>   | AMKR<br><b>Amkor Technology</b> | SPOT<br><b>Spotify</b>               | OKE<br><b>ONEOK</b>             | WGS<br><b>GeneX</b>                    | CP<br><b>CP</b>                      | Bldr<br><b>Builders FirstSource</b> | TWLO<br><b>twilio</b>      | MGA<br><b>MAGNA</b>                             |             |
| CX<br><b>CEMEX</b>   | RIG<br><b>Transocean</b>        | MO<br><b>Altria</b>                  | TTI<br><b>TETRA</b>             | HES<br><b>HESS</b>                     | PPC<br><b>pilgrims</b>               | MIRN<br><b>moderna</b>              | ROKU<br><b>Roku</b>        | BBU<br><b>Brookfield Business Partners</b>      |             |
| ARLP<br><b>ALLIANCE BERCHER PARTNERS LP</b>  | RMB<br><b>Rambus</b>            | FOUR<br><b>Shift4 PAYMENTS</b>       | NGD<br><b>newgold</b>           | ETSY<br><b>Etsy</b>                    | SFM<br><b>SPROUTS FARMERS MARKET</b> | PWR<br><b>QUANTA SERVICES INC.</b>  | AIG<br><b>AIG</b>          | AXL<br><b>AMERICAN AXLE &amp; MANUFACTURING</b> |             |
| http://eps.sh/cal  |                                 |                                      |                                 |  |                                      | © 2025 Earnings Whispers            |                            |   |             |